



НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ (С.ЭНХБАЯР)



АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	2-3
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	3- 7
ГУРАВ.АЛСЫН ХАРАА	7- 7
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	8-8
ТАВ. ҮНЭТ ЗҮЙЛС	8-8
ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ (SWOT)	8-9
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	9-10
НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ	10-10
ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	10-10
АРАВ. ХАВСРАЛТ	10-12

Нэг. Нийтлэг үндэслэл

2020 онд “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдан гарснаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль шинэчлэгдэн батлагдсан. Энэхүү хуулийн дагуу нийслэлийн түвшинд хөгжлийн бодлого нь дараах бүтэц, уялдаатайгаар хэрэгжинэ. Дунд хугацааны баримт бичиг – “Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, богино хугацааны баримт бичиг – “Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” багтана. Эдгээр баримт бичгүүд нь шаталсан, уялдаа холбоотой төлөвлөлтийн зарчмаар хэрэгжих бөгөөд энэ хүрээнд нийслэлийн төрийн байгууллагууд өөрсдийн эрх, чиг үүргийн дагуу стратегийн төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах үүрэгтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтэц, Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийг өөрчлөн зохион байгуулах тухай” А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хяналт шалгалтын газар байгуулагдсан.

Нийслэлийн Хяналт шалгалтын газар нь Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, Нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас хот байгуулалт, барилга, дэд бүтцийн салбар дахь төрийн хяналт шалгалтын талаар баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Энэхүү стратегийг боловсруулахад Монгол Улсын Үндсэн хууль, “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгийг суурь үндэс болголоо.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасан болно. Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар”-ыг харгалзан энэхүү стратегийг боловсруулав.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахад SMART буюу зорилго тодорхой байх (specific), хэмжиж болохуйц (measureable), зорилгодоо хүрч болохуйц байх 4 (achievable), бодитой байх (relevant), цаг хугацаатай байх (time bound efforts) гэсэн олон улсын суурь зарчмыг баримталсан болно.

Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд хот байгуулалт, барилга, дэд бүтцийн салбарт хэрэгжих бүтээн байгуулалт, ашиглалт засварын ажил, үйлчилгээнд хууль тогтоомж, үндэсний болон хотын стандарт,

нормыг мөрдүүлж, төрийн хяналт шалгалтын үр нөлөөтэй байдлыг сайжруулах нь тус газрын үйл ажиллагаа, хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Энэхүү стратеги нь Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025-2028 онд баримтлах бодлогын баримт бичиг юм. Стратегийг батлан хэрэгжүүлснээр ажлын үр дүн, хүртээмжийг дээшлүүлэх болно.

Хоёр. Мандатын шинжилгээ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”, Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу Нийслэлийн Хяналт шалгалтын газрын мандатын шинжилгээг хийлээ.

Мандат нь төрийн байгууллагын хуульд заасан чиг үүрэг болон эрх хэмжээтэй салшгүй холбоотой ойлголт юм. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-д зааснаар “чиг үүрэг” гэж төрийн байгууллага хуульд заасан эрх мэдлийн хүрээнд тодорхой зорилт, үр дүнд хүрэхээр тогтвортой хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэлнэ.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын мандатын шинжилгээгээр чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомжийг үзвэл “ерөнхий чиг үүрэг 5, үндсэн чиг үүрэг 23 байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөж байгаа нийт хууль		17 хууль	
Үүнээс		Тухайн салбарын хууль	3
		Нийтлэг мөрдөгддөг хууль	14
Ерөнхий чиг үүрэг: Газар нь Барилга хот байгуулалт, дэд бүтэц, газрын харилцаа, уг салбарт орчны аюулгүй байдлыг хангуулах хүрээнд төрийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлж, иргэн хуулийн этгээдээс гаргасан өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, үндэсний болон хотын стандартын хэрэгжилтэд хяналт тавина.			
Д/д	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1	Барилга, хот байгуулалтын салбарын төрийн хяналтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ	2.1.барилгын техникийн хяналт	Барилга байгууламжийн ашиглалт бүртгэлийн хэлтэс, бусад хэлтэс
		2.2.хот төлөвлөлтийн хяналт	
		2.3.өргөх байгууламжийн хяналт	
		2.4.усан хангамж, ариутгах татуургын хяналт	
		2.5.барилгын материалын хяналт	
		2.6.усны барилга байгууламжийн хяналт	
		2.7.хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт	
		2.8.газрын харилцаа	

Файлын нэр: Стратеги төлөвлөгөө НХШГ

2	Дэд бүтцийн салбарын төрийн хяналтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ	3.1.эрчим хүчний хяналт (дулаан, цахилгаан)	Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс, бусад хэлтэс
		3.2.газрын тос, хийн хяналт	
		3.3.авто замын хяналт	
		3.4.авто тээврийн хяналт	
		3.5.харилцаа, холбооны хяналт	
		3.6.хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт	
		3.7.газрын харилцаа	
3	Нийслэлийн хэмжээнд баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ	4.1.барилга байгууламж, их засвар тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах	Барилга байгууламжийн ашиглалт бүртгэлийн хэлтэс, бусад хэлтэс
		4.2.барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлтийг баталгаажуулах	
		4.3.ашиглалтад орсон барилга байгууламжийн талаарх мэдээллийг нэгтгэн, холбогдох мэдээллийн санг баяжуулах	
4	Хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дараах үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг жил бүр нийслэлийн удирдлагад тайлагнана.	5.1.хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, сурталчлан таниулах	Хяналт шалгалтын газрын хэлтсүүд
		5.2.барилга, дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг, үндэсний болон хотын стандарт, норм дүрмийн хэрэгжилтийн байдлыг судалж, эрсдлийн үнэлгээ хийх	Дотоод хяналт шинжилгээний хэлтэс, бусад хэлтэс
		5.3.Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журмын дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, түүний үр дүнд илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авах	ББАБХ, БСАБХХ, ДБСХХ, ОАБХХ Нийт хэлтэс
		5.4.Хяналт шалгалтын үр дүнг нэгтгэн дүгнэж, нийслэлийн удирдлага болох холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах	Нийт хэлтэс
		5.5.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг ашиглан тандан судалгаа, эрсдэлийн	Дотоод хяналт шинжилгээний хэлтэс,

	үнэлгээг хийж, цахим мэдээллийн санг холбогдох салбар, чиглэл бүрээр хөтөлж, бүртгэх	бусад хэлтэс
--	--	--------------

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын чиг үүргийг холбогдох хууль, тогтоомжид тулгуурлан тодорхойлсон бөгөөд тухайн чиг үүргийг захиргааны эрх хэмжээний ангиллаар авч үзсэн. Энэ хүрээнд Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг суурь болгон үзвэл дараах байдлаар гарч ирнэ:

1. Бодлого боловсруулах – Үндэсний хэмжээний болон салбар, орон нутгийн урт, дунд, богино хугацааны стратеги зорилт боловсруулах, төлөвлөх, хууль тогтоомжийн төсөл, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт тогтоох, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх чиглэлээр Засгийн газар, яамд болон нутгийн захиргааны байгууллагын эрх хэмжээ хамаарна.

2. Зохицуулалт хийх – Тодорхой үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн байгууллагаас зөвшөөрөл, лиценз, магадлан итгэмжлэх, гэрчилгээ олгох зэрэг эрх хэмжээ хамаарна.

3. Зохион байгуулах – Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээ хамаарна.

4. Санхүүжилт – Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, санхүүгийн дэмжлэг, зардал, хөрөнгө оруулалттай холбоотой эрх хэмжээ хамаарна.

5. Хүний нөөцийн бодлого – Удирдах албан тушаалтан болон албан хаагчдыг томилох, чөлөөлөх, чадавхжуулах, бэлтгэх, давтан сургах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зэрэг эрх хэмжээ хамаарна.

6. Хяналт, үнэлгээ хийх – Төрийн байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт болон дотоод аудит хийх эрх хэмжээ хамаарна.

7. Үйлчилгээ үзүүлэх – Төрөөс үзүүлэх үйлчилгээг төрийн байгууллага болон нутгийн удирдлагын байгууллага, эсхүл гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх хэмжээ хамаарна.

Хүснэгт 2 Чиг үүрэг, эрх хэмжээ

№	Чиг үүрэг	Бодлого боловсруулах	Зохицуулалт хийх	Зохион байгуулах	Санхүүжилт	Хүний нөөцийн бодлого	Хяналт үнэлгээ хийх	Үйлчилгээ үзүүлэх
1	Газар нь барилга, хот байгуулалт, дэд бүтэц, газрын харилцаа, уг салбарт орчны аюулгүй байдлыг хангуулах хүрээнд төрийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, үндэсний			+	+	+	+	+

	болон хотын стандартын хэрэгжилтэд хяналт тавина.							
2	Барилга, хот байгуулалтын салбарын төрийн хяналтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ			+	+	+	+	+
3	Дэд бүтцийн салбарын төрийн хяналтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ			+	+	+	+	+
4	Нийслэлийн хэмжээнд баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ			+	+	+	+	+
5	Хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дараах үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг жил бүр нийслэлийн улирдлагад тайлагнана.			+	+	+	+	+

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Хяналт шалгалтын газар бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэв.

Зураг 1. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын үйл ажиллагаанд холбогдогч талууд



Эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно. Нийслэлийн Хяналт шалгалтын газар нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эдгээр холбогдогч талуудтай харилцах бөгөөд холбогдогч талууд өөрт хамаарах эрх хэмжээний хүрээнд тодорхой үүрэг оролцоотойгоор хамтран ажиллана.

Хүснэгт 3. Холбогдогч талуудын оролцоо

Холбогдогч талууд	Оролцоо					
	Мэдээлэх	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Хяналт тавих
Нийслэлийн Засаг дарга	+	+	+	+	+	+
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	+	+	+	+		+
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	+	+	+	+	+	+
Монгол Улсын Их Хурал	+	+	+	+		
Монгол Улсын Засгийн газар	+	+	+	+		
Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газар	+	+	+	+		
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	+	+	+	+		
Яамд	+	+	+	+	+	
Засгийн газрын агентлагууд	+	+	+	+		
Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд	+	+	+	+		
Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар	+	+	+	+		
Иргэн, Аж ахуйн нэгж байгууллага	+	+	+	+		
Хэвлэл мэдээллийн байгууллагууд	+	+	+	+		

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Олон улсын жишигт нийцсэн үндэсний стандартыг хэрэгжүүлж, шударга хяналтыг эрхэмлэсэн байгууллага болно.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтад стандарт нормыг мөрдүүлж, төрийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлнэ.

ТАВ. ҮНЭТ ЗҮЙЛС

Ёс зүй: Төрийн албаны ёс зүйг дээдлэн сахиж, үнэнч шударга, ил тод байдлыг эрхэмлэн ажиллана.

Манлайлал: Нийслэл хотын хөгжлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхи, санаачилга, хөдөлмөр, зүтгэлээр бусдыг үлгэрлэн манлайлна.

Хамт олон: Албан хаагч бүрийн сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлж, нийслэл хотынхоо төлөө сэтгэл зүтгэлтэй, эрч хүчтэйгээр ажиллах сэтгэл зүйн болон ажлын таатай орчныг бий болгох байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.

Хариуцлага: Хариуцсан ажлынхаа чанар, гүйцэтгэлийг төлөвлөсөн хугацаанд нь, зорилтот түвшинд нь хүргэхийн төлөө оюун ухаан, хүч хөдөлмөрөө дайчлан ажиллана.

Ур чадвар: Орчин үеийн техник, технологи, ололтот туршлагыг эзэмшиж үнэ цэнээ нэмэгдүүлэн төрийн албан хаагч болон хувь хүний хувьд тасралтгүй хөгжинө.

ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ (SWOT)

Нийслэлийн Хяналт шалгалтын газар өмнө тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд SWOT болон PESTLE шинжилгээг дотоод болон гадаад хүчин зүйлийн хүрээнд хийлээ.

Стратегийг боловсруулахын тулд хуулийн хүрээнд тодорхойлогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхын өнөөгийн давуу, сул тал, орчны нөлөөллийн боломж, эрсдэлийг илэрхийлэх гол хүчин зүйлсийг тус тус сонгож авсан болно. Стратегийн зорилтыг тодорхойлохдоо тус шинжилгээний үр дүнд тулгуурлан давуу талдаа түшиглэн, сул талаа бууруул ахад чиглэсэн арга замыг сонгож, гадаад орчны боломжийг ашиглаж, эрсдэлийг бууруулах зарчмыг баримталсан.

Хүснэгт-4 Орчны шинжилгээ

ДОТООД ОРЧИН	
<u>Давуу тал</u> 1.Ажлын байрны тохижилт сайн, ажиллах орчин таатай 2.Хамт олны уур амьсгал сайн, хамтран ажиллах боломж өндөр 3.Техник хэрэгсэл, программ хангамжийн нөөц сайн	<u>Сул тал</u> 1.Ажлын ачаалал их, гэнэтийн яаралтай ажлууд 2.Ажлын байр хол, түгжрэлтэй, байрны агааржуулалт муу

4.Ажлын байрны болон хүний нөөцийн сургалтууд сайн хийгддэг 5. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн 6. Хүний нөөцийг мэргэжлийн мэргэшсэн албан хаагчдаар бүрдүүлсэн	3.Нийгмийн баталгаа ялангуяа орон байраар хангагдах, хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломж байна 4.Ур чадвар нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтын төлбөрийг шийддэг байх 5.Амралтын өрөө хангалтгүй 6.Илүү цагаар суух, хөдөлгөөний хомсдол, ажлын стрессээс үүдэлтэй эрүүл мэндийн асуудлууд 7.Ажлын бус цагаар, баярын, амралтын өдрүүдэд шуурхай удирдлагын утсаар ирсэн гомдол зөрчлийн дуудлагаар улсын байцаагч нар өөрийн унаагаар ажилладаг боловч шатахууны талон, илүү цаг олгогддоггүй 8.Хяналтын ажлын үед хамгаалах хэрэгслээр /энгэрийн камер, дуу хураагуур гэх мэт/ хангагдаагүй 9.Гадаад дотоодод хурал, семинар сургалтуудад оролцох, туршлага судлах боломж дутмаг 10.Алслагдсан дүүрэг болох Багахангай, Багануур, Налайх дүүрэгт ажилласан тохиолдолд томилолтын зардал байдаггүй 11. Хүний нөөц дутагдалтай
ГАДААД ОРЧИН	
<u>Боломж</u> 1.Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцох боломж.	<u>Эрсдэл</u> 1.Улс төрийн нөлөөлөл их, бодлого тогтворгүй байдал 2.Өргөдөл гомдол, зөрчлийн дуудлагаар ганц нэгээрээ хяналт шалгалтаар очих 3.Хамгаалах хэрэгсэлгүй 3.Илүү цагаар ажиллах, ажлын стрессээс шалтгаалан ажлаас гарах эрсдэл өндөр.

SWOT шинжилгээ нь байгууллагын дотоод давуу болон сул тал, гадаад орчны боломж ба аюул заналыг илрүүлэн тодорхойлох стратегийн чухал хэрэгсэл юм.

Энэхүү шинжилгээний зорилго нь байгууллагын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, цаашдын хөгжлийн стратегийг оновчтой төлөвлөхөд оршино.

SWOT шинжилгээ хийснээр байгууллага дотоод нөөц боломжоо бүрэн ашиглах, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх, мөн гадна орчны эерэг боломжийг ашиглан сөрөг нөлөөллөөс сэргийлэх суурь мэдээллийг олж авдаг. Иймд SWOT шинжилгээ нь стратеги төлөвлөгөө боловсруулах үйл явцын тулгын чулуу болж өгдөг бөгөөд байгууллагын удирдлагад шийдвэр гаргахдаа баримтлах бодит үндэслэл, нотолгоог бүрдүүлдэг.

Энэхүү тайланд Нийслэлийн Хяналт шалгалтын газрын бүтэц нэгжүүдийн орчны шинжилгээнд үндэслэн, нийслэл хотын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах үүрэгтэй.

Гадаад орчны хувьд SWOT шинжилгээг баяжуулан PESTLE шинжилгээ давхар хийх замаар тодорхойллоо.

Хүснэгт 5

Үзүүлэлт	Хамаарах гол зэрэг, сөрөг хүчин зүйлс	Нэмэлт тайлбар
Улс төр	- Удирдлагын шууд дэмжлэг - Улс төрийн тогтворгүй байдал	Газар нь нийслэлийн Засаг даргад харьяалагддаг тул хотын удирдлага солигдох, бодлогын өөрчлөлтөөс шалтгаалан бүтэц, чиг үүрэг өөрчлөгдөх, эрсдэлтэй. Гэхдээ хууль, захирамжаар тогтоосон статус нь давуу тал болж байна.
Эдийн засаг	- Төсөв, санхүүгийн тогтвортой байдал - Эдийн засгийн хямралын эрсдэл	Байгууллага санхүүгийн хувьд сайн нөхцөлтэй ч улс орны эдийн засгийн хямрал нь төсөвт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
Нийгэм	- Залуучууд давамгайлсан хүний нөөц - Сургалт хөгжлийн боломж - Хамт олны уур амьсгал, уян хатан цагийн бодлого - Иргэдийн итгэл, олон нийтэд танигдах байдал	Ажилтан, албан хаагчид залуу, эрч хүчтэй, уян хатан цагийн зохицуулалттай. Сургалт, хамтын ажиллагаа сайн.
Технологи	- Орчин үеийн программ хангамжийн хэрэглээ - Хиймэл оюун ухаан, их өгөгдөл нэвтрүүлэх боломж - Интернэт, дотоод сүлжээний хүндрэл	Техник, программ хангамжийн чадавх сайн
Хууль эрх зүй	Тогтоол, захирамжаар баталгаажсан статус	Байгууллагын үйл ажиллагаа эрх зүйн үндэслэлтэй
Байгаль орчин	- Агаар, орчны бохирдол, тоосонцор ихтэй бүсэд байрладаг - Ногоон оффис, эко орчныг бүрдүүлэх - Эрчим хүчний хэрэглээ өндөр	Байршил алс, агааржуулалт муу, оффисын байршлаас шалтгаалан цаг ашиглалт мууддаг зэрэг нь тухайн байгууллагын дотоод орчны тав тух, үр бүтээмжид сөргөөр нөлөөлж байна.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО


Стратегийн хүрээнд дараах зорилтыг /зорилгыг/ хэрэгжүүлнэ:

1. Хотын стандарт нормыг мөрдүүлж хэвшүүлнэ.
2. Төрийн хяналт шалгалтын үр нөлөөтэй байдлыг хэрэгжүүлнэ.

Файлын нэр: Стратеги төлөвлөгөө НХШГ

3. Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ



ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6

Зорилго	Зорилт	Арга зам	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
1.Хотын стандарт нормыг мөрдүүлж хэвшүүлнэ	1.1. Хотын стандарт, нормыг мөрдүүлж, ил тод хяналттай, иргэдийн оролцоонд тулгуурласан тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн тогтолцоог хэвшүүлнэ.	Төслүүдэд хотын стандартыг мөрдүүлж, хяналтыг цахимжуулах, иргэдийн оролцоог ханган ажилтнуудын чадавхийг нэмэгдүүлнэ	-Стандартын шаардлага хангасан төслийн хувь	90%	95%	-
			-Хяналт шалгалтыг цахимжуулсан байдал хувь	-	70%	
			-Иргэдийн гомдол санал буурсан байдал	70%	90%	
			-Сургалтын дараах үр дүн		100%	
2.Төрийн хяналт шалгалтын үр нөлөөтэй байдлыг хэрэгжүүлнэ	2.1 Хяналт шалгалтыг үр дүнтэй, ил тод иргэдийн оролцоонд суурилсан мэргэжлийн чадавхтай тогтолцоог хэрэгжүүлж бодит үр дүнд хүргэнэ	-Хяналтын үйл ажиллагааг системтэй төлөвлөх, эрсдэлд суурилсан хяналт хийх -Тайланг нээлттэй мэдээлэх -Шалгалтын санал зөвлөмжийг бодит үр дүнд хүргэх	-Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт (хувь)	90%	95%	-
			-Ил тод мэдээлэгдсэн тайлангийн хувь	100%	100%	
			-Зөвлөмжийн хэрэгжилт	90%	95%	
3.Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.	3.1 Барилга зам, дэд бүтцийн салбарын хяналтын үйл ажиллагааг тогтвортой хөгжилд нийцүүлэн ил тод, хариуцлагатай, инновацид	-Ил тод цахим засаглалыг төлөвшүүлэх -Хууль эрх зүйн орчныг шинчлэх -Иргэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	-Цахимжсан үйлчилгээний хувь	-	90%	-
			-Шинэчлэгдсэн стандарт норм журмын тоо	-	1	
			-Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	95%	100%	

	тулгуурласан засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	-Байгууллагын чадавхийг бэхжүүлэх	-Сургалтын дараах үр дүн			
	3.2. Зорилго алсын хараа, стратегийг сайжруулна	Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт зохион байгуулалтыг "Алсын хараа-2050" болон нийслэлийн хөтөлбөртэй уялдуулан сайжруулах	-Төлөвлөлтийн уялдаа хангагдсан байдал (%)	-	100%	-
		-Стратегийн зохион байгуулалт, бүтээмжийг нэмэгдүүлэх	-Гүйцэтгэл, өөрчлөлтийн удирдлагыг сайжруулсан байдал (%) -Ажлын ачаалал, бүтээмжийн байдал (%)	-	100%	-
	3.3. Байгууллагын соёл ба манлайлалыг хөгжүүлнэ	-Манлайлал, хамтын ажиллагаа, ёс зүйн сургалт зохион байгуулах -Дотоод харилцаа мэдээлэл солилцоог сайжруулах -Байгууллагын үнэт зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх үнэлгээ хийж санал авах	-Сургалтад хамрагдсан ажилтны хувь	90%	100%	-
			Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн (%)	-	90%	
			-Үнэт зүйлсийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо, хувь	90	100%	
	3.4. Оролцогч талуудын оролцоог хангуулна	-Талуудыг шийдвэр гаргалт, төлөвлөлтөд идэвхтэй оролцуулах	-Оролцогч талуудын оролцсон уулзалт хэлэлцүүлэгээс гарсан шийдвэр, үр дүн	-	100%	-

		-Санал гомдол, зөвлөмж хүлээн авах, оролцоог нэмэгдүүлэх сургалт семинарь зохион байгуулах -Ил тод мэдээлэл тайланг нийтэд танилцуулах	-Иргэд байгууллагын саналын шийдвэрлэгдсэн хувь			
			-Сургалт семинарын дараах үр дүн	90%	100%	
			-Нийтэд мэдээлэгдсэн тайлангийн хувь	95%	100%	
	3.5. Тогтвортой үнэ цэнийг бий болгоно	Үйл ажиллагаа, төслийн чанарыг дээшлүүлж тогтвортой байдлыг хангах, -Оролцогч талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	-Тогтвортой байдлын үнэлгээний дүн (%)	-	90%	-
			-Оролцогч талуудын хамтын ажиллагааны түвшин(%)	90%	95%	
	3.6. Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулна	-Төсөл үйл ажиллагааны гүйцэтгэлийг тогтмол үнэлэх, тайлагнах -Өөрчлөлт шинэчлэлийг удирдах процессыг стандартчилах -Мэргэжлийн сургалт чадавхийг сайжруулах	-Гүйцэтгэлийн тайлангийн боловсруулалт (%)	-	90%	-
			-Өөрчлөлт хэрэгжүүлсэн төслийн хувь	-	90%	
			-Сургалтын дараах үр дүн	90	95%	
	3.7. Оролцогч талуудын сэтгэл ханамж ойлголт	-Оролцогч талуудын санал гомдол, хүсэлтэд шуурхай хариу өгөх -Үйл ажиллагааны чанарыг сайжруулах	-Хариу өгсөн саналын хувь	100%	100%	-
			-Сэтгэл ханамжийн судалгааны дүн (%)	90%	100%	
			-Оролцогч талуудын оролцсон үйл ажиллагааны хувь	90	95%	

		-Иргэд байгууллагуудын оролцоог идэвхжүүлэх				
	3.8. Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэл	-Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хянах	-Төлөвлөгөөний хэрэгжилт хувь	-	90%	-
		-Дүн шинжилгээ хийж санал зөвлөмж гаргах	-Гүйцэтгэлийн хувь		95%	

АРАВ. ХАВСРАЛТ

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын албан хаагчдаас авсан судалгааны нэгтгэл /10 хуудас/.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын албан хаагчдын амьдралын нөхцөл, ажиллах орчин, нийгмийн баталгаа, тулгамдсан асуудал, ирээдүйн хэрэгцээг тодорхойлоход чиглэгдсэн бөгөөд 61 албан хаагчийг хамруулан 6 бүлэгт хуваан 31 асуултаар явуулсан болно.

Судалгааны үр дүнгээс үзэхэд дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Цалин, орлого болон орон сууцны асуудал нь албан хаагчдын хамгийн том тулгамдсан асуудал болж байна. Цалин нэмэх, орон сууцны нөхцөлийг сайжруулах нь нэн тэргүүний шаардлага юм.
- Амралт, нөхөн сэргэлт, төрийн халамж, урамшууллын тогтолцоо зэрэг нь ч мөн анхаарал татаж байгаа тул эдгээрийг сайжруулах шаардлагатай байна.
- Ажиллах орчин, ялангуяа ажлын байрны тохижилт, тоног төхөөрөмж, программ хангамжийн хүртээмжийг сайжруулах нь ажиллах хүчинд эерэг нөлөө үзүүлнэ.
- Эрүүл мэндийн дэмжлэг, нэмэлт даатгалын хүрээг өргөжүүлэх нь албан хаагчдын нийгмийн баталгааг нэмэгдүүлнэ.
- Албан хаагчдад сургалт, мэргэжил дээшлүүлэх, гадаадад сурч боловсроход дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

Эдгээр дүгнэлтээс үндэслэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх саналтай байна. Үүнд:

- Цалин, орлого нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх
- Орон сууцны нөхцөлийг сайжруулах, дэмжлэг үзүүлэх
- Ажиллах орчныг шинэчлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжаар бүрэн хангах
- Ажлын хуваарилалт, үүргийн зохистой байдлыг хангах, хүний нөөцийг нэмэгдүүлэх
- Нийгмийн халамж, урамшууллын системийг сайжруулах
- Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэг, даатгалын хамралтыг өргөжүүлэх
- Албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх сургалт, туршлага солилцох хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлэх

Нөхцөл байдлын шинжилгээг дүгнэн харвал

Нийслэлийн Хяналт шалгалтын газар нь дотоод нөөц бололцооны хувьд харьцангуй сайн байгууллага юм. Ажиллах орчин, техник технологийн хангамж сайн, чадварлаг залуу хүний нөөцтэй, хамтран ажиллах эерэг соёл бүрдсэн байгаа нь цаашдын хөгжил дэвшлийн бат суурь болж байна. Мөн хууль эрх зүйн хувьд бие даасан статустай, нийслэлийн шийдвэр гаргах түвшинд нөлөөлөхүйц байр суурьтай байгаа том давуу тал билээ. Түүнчлэн гадаад орчны улс төр, мэдээллийн тогтворгүй байдал, байгууллагын нэр хүнд, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэлүүдийг анхаарах хэрэгтэй. Эдгээрийг зохицуулан шийдвэрлэснээр тус газар нь өөрийн давуу талуудаа бүрэн ашиглаж, боломжуудаа бодит ажил хэрэг болгох замаар үндсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэх боломжтой.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын үйл ажиллагааг
зохицуулсан эрх зүйн баримт бичгийн жагсаалт

Холбогдох хуулиуд

1. Монгол Улсын Үндсэн Үндсэн хууль
2. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Төрийн албаны тухай хууль
6. Хөдөлмөрийн тухай хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Захиргааны ерөнхий хууль;
9. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
10. Хууль тогтоомжийн тухай хууль;
11. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
12. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
13. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
14. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
15. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
16. Барилгын тухай хууль
17. Салбарын бусад хуулиуд

Холбогдох тогтоол, захирамжууд

1. Засгийн газрын тогтоол №43 “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”. 2025
2. Засгийн газрын тогтоол №246 “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” 2021.12.30
3. Засгийн газрын тогтоол №33 “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”. 2019.01.23 28
4. Засгийн газрын тогтоол №216 “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”. 2020.12.16
5. Засгийн газрын тогтоол №217 “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”. 2020.12.16
6. Засгийн газрын тогтоол №218 “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”. 2020.12.16
7. Засгийн газрын тогтоол №479 “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” 2022 он
8. ЗГХЭГ даргын тушаал №100 “Стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, тайлангийн загварууд”. 2020.12.31
9. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол №65 “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”. 2022.02.22

10.НЗД захирамж №А/1049 “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай”. 2022.08.15

11.НЗД захирамж №А/552 “Нийслэлийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас Засгийн газрын шийдвэрийн төсөл санаачлан боловсруулах журам”. 2022.04.22

12.НЗД захирамж №А/52 “Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”. 2022.02.02

13.НИТХ тогтоол №66 “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”. 2014.05.05

14.НЗД захирамж №А/277 “Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүн, хуралдааны журам”. 2022.02.2

Товчилсон үгийн жагсаалт:

ББАБХ-Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэс,

БСАБХХ-Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс,

ДБСХХ-Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс,

ОАБХХ-Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс

ДХШХ-Дотоод хяналт, шинжилгээний хэлтэс

ЗСХ-Захиргааа, санхүүгийн хэлтэс

----- 000 -----